

Олон Улс Судлал №4, 2014 он: хуудас 32-38.

## Худалдаа Хөгжлийн банк-Хятадын банкуудтай хийж буй хамтын ажиллагаа

Б.Мэдрээ\*

*Товч агуулга:* Энэхүү танилцуулгад “Монгол улс-БНХАУ-ын харилцаа, хамтын ажиллагаа” сэдвийн хүрээнд Монгол, Хятадын хөгжлийн үе шатуудад байгуулсан худалдааны холбогдолтой гэрээ хэлэлцээрүүдийг схемчлэн үзүүлж Монгол Улсын худалдааны өнөөгийн нөхцөл болон Худалдаа хөгжлийн банкны талаар тойм мэдээлэл өгнө. Мөн Худалдаа хөгжлийн банк, Хятадын банк болон банк санхүүгийн байгууллагуудтай хийж буй хамтын ажиллагааны төлөв байдлыг товч танилцуулж цаашдын хамтын ажиллагааны боломжийн талаар өгүүлнэ. Тухайлбал стратегийн ач холбогдол бүхий томоохон төслүүдийн хүрээнд своп хэлцлийг ашиглах, хоёр улсын банкуудын корреспондент харилцааг эрчимжүүлэх, санхүүжилтийн төрлийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийн хүрээнд хамтран ажиллах, гадаад худалдааны санхүүжилтийн нэр төрлийг нэмэгдүүлэх боломж, арга замуудын талаархи асуудлыг хөндөж мөн зарим нэгэн саналыг дэвшүүлсэн юм.

\* \* \*



Хил худалдааны төлбөр тооцоо нээлттэй болсон үеэс буюу 2002 онд Монголбанк, БНХАУ - ын Ардын банктай “Хил худалдааны төлбөр тооцооны гэрээ” – г үзэглэсэн. ХХБ нь 2002 онд Монгол Улсаас анхлан БНХАУ - ын Хөдөө Аж Ахуйн банктай “Юанийн төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулж, данс нээн, хамтын ажиллагааг эхлүүлж байсан түүхтэй.

ХХБ нь 2002 – 2010 онуудад Хятадын 6 банк, санхүүгийн байгууллагуудтай хил худалдааны төлбөр тооцооны гэрээ, юань, ам.долларын төлбөр тооцооны гэрээ, зээлийн эрхийн гэрээ, бэлэн

\* Худалдаа Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал

мөнгөний зузаатгалын гэрээ, импортын санхүүжилтын зэрэг гэрээнүүдийг байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлж ирсэн.

ХХБ нь 2010 – 2014 онуудад Хятадын банк, санхүүгийн байгууллагуудтай хийж буй хамтын ажиллагаагаа улам идэвхжүүлж, шинээр 7 банктай бизнес чиглэлүүдийн хүрээнд холбогдох гэрээг байгуулсан. Хуучин гэрээнүүдийг шинэчлэн байгуулснаар төлбөр тооцоо болон худалдааны санхүүжилтын нөхцлийг сайжруулан ажиллаж байна.

Бизнес хамтын ажиллагааны чиглэл:

- Худалдааны санхүүжилт
- Гадаад гуйвуулга
- Валют арилжаа, хэлцэл
- Бэлэн мөнгөний зузаатгал
- Байршуулсан хадгаламж
- Олон улсын картын төлбөр тооцоо

Хятад - Монголын арилжааны банкуудын хамтын ажиллагааны суурийг тавьсан ХХБ нь өдгөө Хятадын томоохон банк болон банк санхүүгийн байгууллагуудтай хэд хэдэн чиглэлийн хүрээнд хамтран ажиллаж байна.

Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд Хятадын банкуудтай хийж буй бизнес хамтын ажиллагааны хүрээнд Хятадын банкуудаас ХХБ - нд баталсан зээлийн шугамыг үйлдвэрлэл, худалдаа, барилга бүтээн байгуулалтын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй дотоодын бизнес эрхлэгчдэд богино хугацааны зээл хэлбэрээр олгож байна.

### **Цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж**

*Банк, санхүүгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж:*

■ Монголбанк, Хятадын Ардын банктай байгуулсан Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох 15 тэрбум юанийн своп хэлцэл нь дараах зорилготой. Үүнд:

## ОЛОН УЛС СУДЛАЛ

1. Гадаад валютын дотоодын захад тогтвортой байдлыг хангах үүднээс шаардлагатай тохиолдолд гадаад валютын зах дээр төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх;

2. Хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх зэрэг болно.

1. Монгол - Хятад улсуудын гадаад худалдааны салбарыг улам өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг хялбарчлахад своп хэлцлийг ашиглах боломж, арга замууд:

I. Хятад Улсын банкууд Монгол Улсын арилжааны банкуудад юанийн эх үүсвэртэй зээлийг Монголбанкаар дамжуулан своп хэлцэл хийн олгосноор дотоодын бизнес эрхлэгчдэд төгрөгийн эх үүсвэртэй зээл олгон, бизнесийн таатай орчинг бүрдүүлэхэд томоохон дэмжлэг болно.

II. Өнөөгийн байдлаар дээрх своп хэлцлийг зөвхөн бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоо гүйцэтгэх хэлбэрээр ашиглаж байна. Цаашид своп хэлцлийн дүнг нэмэгдүүлэн, гадаад худалдааны төлбөрийн хэрэгсэл (аккредитив, баталгаа) - д давхар ашиглах боломжтой.

III. Санхүүгийн деривативууд нь хөрвөх чанар өндөр тул хоёр улсын арилжааны банкууд хамтран үйл ажиллагаандаа идэвхтэй ашиглах зорилгоор Хятад улсын санхүүгийн зах зээл дээрээс хөрөнгө босгох, хадгаламж татах зэрэгт своп хэлцлийг ашиглах боломжтой. Үүний тулд Монголбанк болон Хятадын төв банкууд холбогдох дүрэм журам, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлж өгөх шаардлагатай байна.

2. Хоёр улсын банкуудын корреспондент харилцааг эрчимжүүлэх, санхүүжилтын төрлийг нэмэгдүүлэх боломж, арга замууд:

1. Шууд зээл (Bank to Bank loan)

Хятад Улсын банкууд Монгол Улсын арилжааны банкуудад урт хугацаатай, бага хүүтэй шууд зээл олгох замаар хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой. Тухайлбал, ОХУ - ын Хөдөө аж ахуйн банк ХХБ - нд 50.0 орчим сая ам.долларыг 2 жил хүртэлх хугацаатай шууд зээл хэлбэрээр олгосон.

## II. Хамтын санхүүжилт (Syndicated loan)

Монголын арилжааны банкуудын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор хамтын санхүүжилтын зээл олгох боломжтой. Ингэснээр санхүүжилт шаардлагатай байгаа бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдийг дэмжих юм. Жишээлбэл, Монгол Улсаас ХХБ анх удаа олон улсын санхүүгийн зах зээл дээр 82.0 сая ам.долларын “Хамтын санхүүжилтын зээл” - ийг авсан.

## III. Хамтарсан санхүүжилт (Co - financing)

Эдийн засаг, стратегийн өндөр ач холбогдол бүхий томоохон төсөл хөтөлбөрүүдийг хоёр талын банкууд хамтран санхүүжүүлэх боломжтой.

## IV. Төслийн санхүүжилт (On - lending)

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих зорилгын хүрээнд хүү багатай, урт хугацаатай хөрөнгө оруулалтын төслийн зээлүүдийг Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (JICA), Германы КфВ банк (KfW) – уудтай хамтран удаан хугацаанд, тогтвортой олгосоор ирсэн. Үүнтэй ижил төстэй жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх урт хугацаатай, хүү багатай зээлийг Хятад улсын Засгийн газар болон Хятадын банкуудтай хамтран олгож, санхүүжилтын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх боломжтой.

3. Гадаад худалдааны санхүүжилтын нэр төрлийг нэмэгдүүлэх боломж:

I. Хятадын экспорт, зээлийн даатгалын Sinosure корпорацийн аккредитивын зээл

Хятадын даатгалын бодлого тодорхойлогч экспорт, зээлийн даатгалын Sinosure корпорацийтай аккредитивын зээл олгож буй экспортлогчийн банкны зээлийн эрсдлийг даатгах зорилгоор 2005-2008 онд хэрэгжих гэрээ байгуулсан боловч уг зээлийн **экспортлогчид тавигдах шалгуур** (Хятадын топ аж ахуйн нэгжүүд л хамрагдах боломжтой) болон **шимтгэл даатгалын хураамж өндөр** (Sinasure-д гэрээний үнийн дүнгийн 4.0%-иар даатгалын хураамж төлдөг) зэрэг

шалтгаанаар зээл олгогдоогүй байна.

Энэхүү Sinosure корпорацитай хийгдэж байсан зээлийн бүтээгдэхүүнийг дахин үргэлжлүүлж дэд бүтэц, барилга угсралт, хүнс болон өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи, тэдгээрт холбогдох тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа бүтээгдэхүүн, ажил болон үйлчилгээг БНХАУ-аас худалдан авах гэрээг санхүүжүүлэн, эдийн засгийг эрчимжүүлэх боломж байна.

Тухайлбал, олон улсын томоохон банкууд болох Герман улсын Commerzbank (15.0 сая евро), АКА bank (10.0 сая евро), Korea Exim-Bank (30.0 сая ам.доллар) зэрэг банкууд нь ХХБ-нд Экспорт кредит агент (ЕСА)-ын даатгалтай худалдааны санхүүжилтын зээлийг олгож байна.

1. Хятадын экспорт импортын банкны тусгай нөхцөлтэй зээл:

Хятадын Засгийн газар, Хятадын экспорт импортын банкаар дамжуулан Засгийн газрын тусгай нөхцөлтэй зээл болон импортлогчийн тусгай нөхцөлтэй зээл гэсэн 2 төрлийн тусгай нөхцөлтэй зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжиж буй орнуудыг дэмжих зорилгоор олгодог байна. Иймд, гадаад худалдаа, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөрийг дэмжих, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих зэрэг зорилгын хүрээнд хүү багатай, урт хугацаатай хөрөнгө оруулалтын төслийн зээлүүдийг санхүүжүүлэх зорилгоор уг зээлийн бүтээгдэхүүнийг Монголд нэвтрүүлэх боломжтой.

4. Хөрөнгийн зах зээлийн хүрээнд хамтран ажиллах боломж:

Хятадын хөрөнгийн зах зээлд Монголын компаниудын юанийн бонд (Dimsum bond, CNH bond) - ыг арилжих боломжийг нэмэгдүүлэх. Тухайлбал, ХХБ 2014 онд богино хугацаатай оффшор юанийн бонд амжилттай арилжиж, 700 сая юанийн хөрөнгө оруулалт төвлөрүүлсэн. Энэхүү Dimsum бонд нь оффшор юанийн бүсэд Хятадын хөрөнгө оруулалтгүй компани юанийн бонд арилжснаараа онцлог болсон.

Стратегийн ач холбогдол бүхий томоохон төслүүдийн хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх:

5. Стратегийн ач холбогдол бүхий томоохон төслүүдийн хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх:

I. Монгол Улсын Уул уурхайн яам, Хятадын Газрын тос - химийн корпораци “SINOPEC” - ийн хооронд байгуулсан санамж бичиг:

- 2013 онд МУ - ын Уул уурхайн яам, Хятадын Газрын тос - химийн корпораци “SINOPEC” - ийн хооронд Монголын хүрэн нүүрсний ордыг түшиглэн, 15 тэрбум шоо дөрвөлжин метр хэмжээний шатах хийн хүчин чадалтай, 20000 ажлын байр бүхий үйлдвэр байгуулж, уг үйлдвэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах, улмаар Хятадын зах зээлд борлуулах зорилго бүхий харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Энэхүү үйлдвэр нь жилд 1 тэрбум ам.долларын өртөгтэй 50 орчим сая тонн хүрэн нүүрсний түүхий эд ашиглах бөгөөд байгаль орчинд ээлтэй эрчим хүчний эх үүсвэр бий болгоно.

II. Монгол Улс, Хятад улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр:

- Монгол Улсын ашиглах нэр заасан далайн боомтыг тоог нэмэгдүүлж, Хойд Хятадын бүс нутаг болон Зүүн Хойд Хятадын бүс нутгийн гадаад худалдаанд нээлттэй Дандонт, Далиен, Жиньжоу, Ингкоу, Цинь Хуангдао, Хуанг Хуа, Тяньжин зэрэг нийт 7 боомтыг ашиглахаар ярилцсан. Далайн боомтод хүрсэн Монгол Улсын ачааг гуравдагч улсын хөлөг онгоцоор тээвэрлэх боломжийг бүрэн нээсэнээр хоёр улсын гадаад худалдаа, тээврийн салбарыг хөгжүүлэх үндсэн хөшүүрэг болох юм.

III. Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор:

- Гангийн үйлдвэр
- Нүүрс хийжүүлэх үйлдвэр
- Төмрийн хүдрийн хорголжийн үйлдвэр
- Зэс хайлуулах үйлдвэр
- Дулааны цахилгаан станц
- Коксын үйлдвэр
- Ангижруулсан төмрийн үйлдвэр

IV. Төмөр замын хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд:

- Хоёр улсын хооронд хилийн төмөр замын шинэ боомтууд байгуулах;
- Монгол - Хятад улсуудын хооронд хилийн төмөр замын шинэ боомтууд байгуулах замаар Ази - Европын хооронд хоёр улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх төмөр замын тээврийг идэвхтэй хөгжүүлж, дамжин өнгөрөх тээврийн хэмжээг үлэмж нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах;
- Төмөр замын тээврийн салбарын боловсрол, судалгаа шинжилгээний чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, түүнчлэн, Монгол Улсад Зам, харилцааны их сургууль байгуулах чиглэлээр хамтран ажиллах.